



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 13

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. Төрийн албан хаагчдад олгосон нэг удаагийн тэтгэмжийн зардлаас тусгай зөвшөөрлийн комиссын гишүүдийн урамшуулалд 1370.0 мянган төгрөг олгосон.
2. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас ажиллагсдын ажлын хослолын үнэнд төсвөөс 1500.0 мянган төгрөгийг урьдчилан төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" гэсэн заалтыг, Монгол Улсын Их Хурлын 2017 оны "Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны "Урамшуулал олгох тухай" 52 дугаар тэмдэглэлийг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторовын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

D:\2018 on akt\EMG akt -,docx


2517053

1. Зориулалт бусаар зарцуулсан 2870,0 /Хоёр сая найман зуун далан мянган/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга А.Ганболд, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН <sup>1</sup>:

АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ

ЗӨВШӨӨРСӨН:

БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
А. ГАНБОЛД

НЯГТЛАН БОДОГЧ  
П.ОЮУНТУНГАЛАГ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 14

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

Цалингийн тооцооллыг давтан шалгахад ажиллагсдад олгосон хоолны мөнгөнөөс ХХОАТ-ыг суутган тооцохдоо НДШ хассан дүнгээс тооцож татварын 455627 төгрөгийг ажиллагсдын цалингаас дутуу суутгасан байна.

Энэ нь ХХОАТ-ын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т “бэлнээр олгосон хоолны мөнгө...”, 22.1.4-т “шууд бус орлогод ногдуулах албан татварыг тухайн орлогын дүнгээр”, 23.1-т ... 22.1.4-т зааснаар тодорхойлсон орлогын жилийн дүнд 10 хувиар тооцож албан татвар ногдуулна” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 д “Улс болон орон нутгийн төсөв... орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Ажиллагсдаас дутуу суутгасан ХХОАТ-ын 455627 /Дөрвөн зуун тавин таван мянган зургаан зуун хорин долоон/ төгрөгийг холбогдох хүмүүсээс суутган Баянхонгор аймгийн Татварын хэлтсийн ХХОАТ-ын суутганы орлогын 100030000901 тоот дансанд төвлөрүүлэх.

D:\2018 on akt\EMG akt.docx

2517055

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянхонгор аймгийн Эрүүл мэндийн газрын дарга А.Ганболд, нягтлан бодогч П.Оюунтунгалаг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН <sup>1</sup> :	ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР 	БАЯНХОНГОР АЙМГИЙН ЭРҮҮЛ
А.ЦЭЭНЯМ	МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА
	А. ГАНБОЛД
	НЯГТЛАН БОДОГЧ 
	П.ОЮУНТУНГАЛАГ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 18

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай ротын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

Авлага, өглөгийн дансыг дэлгэрэнгүй бүртгэлээс анхан шатны баримттай тулган нийгмийн даатгалын шимтгэлийн тооцоог шалгахад 24847 төгрөгийн шимтгэлийн авлагыг тайланд дутуу тусгасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.2-т "Бүх хөрөнгө, ХО-г авлага, өглөг"-ийг санхүүгийн тайланд заавал бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.1 д "... орлогыг дутуу төвлөрүүлсэн эсвэл төвлөрүүлээгүй" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**






1. Илүү төлсөн НДШ-ийн авлага 24847 /Хорин дөрвөн мянга найман зуун дөчин долоон/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

D:\2018 on akt\ZH-nii 143 r angi akt .docx

2517063

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Зэвсэгт хүчний 143 дугаар тусгай ротын захирагч Д.Алтанхуяг, нягтлан бодогч Т.Жаргалмаа нарт хариуцуулав.

АКТЫГ

<p>ТОГТООСОН<sup>1</sup>:</p> <p>АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ</p> 	<p>ЗӨВШӨӨРСӨН:</p> <p>ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 143 ДУГААР ТУСГАЙ РОТЫН ЗАХИРАГЧ  Д.АЛТАНХУЯГ НЯГТЛАН БОДОГЧ  Т.ЖАРГАЛМАА</p> 
---	---

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.